



БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СОРТЫН ГАЗРЫН ДАРГА

Ж.ГАНБОЛД
2016 он 06. сарын 23. өдөр



БАТЛАВ.
“МОНГОЛЫН ЖУДО БӨХИЙН
ХОЛБОО”-НЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

М.БӨХБАТ

2016 он 6. сарын 25. өдөр

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

16 оны 06 дугаар
арын 24-ний өдөр

№ 11.158

Улаанбаатар
хот

Энэхүү “Хамтран ажиллах гэрээ” /цаашид “Гэрээ” гэх/-г нэг талаас
ийслэлийн Биеийн тамир, спортын газар, түүнийг төлөөлж Оюутны шигшээ
гийн ахлах дасгалжуулагч Θ.Рагчаадорж /цаашид “Захиалагч” гэх/, нөгөө талаас
онголын Жүдо бөхийн холбоо, түүнийг төлөөлж хуулийн зөвлөх Д.Дашбямба
цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ нь дараах нөхцлөөр
рилцан тохиролцож байгуулав.

НЭГ. Ерөнхий зүйл

- 1 Энэхүү гэрээгээр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо зохион
байгуулагдах Олон улсын Жүдо бөхийн холбооны дэлхийн чансааны оноо
олгох “Чингис Хаан Гран при Улаанбаатар 2016” жүдо бөхийн тэмцээн болон
“Рио 2016” Олимпийн их наадамд оролцох Нийслэлийн Засаг даргын
дэргэдэх оюутны шигшээ багийн жүдо бөхийн тамирчин Д.Сумьяа,
Ц.Наранжаргал, М.Ууганжаргал, Д.Төмөрхүлэг, Л.Отгонбаатар нарыг бэлтгэл,
сургуулилт хийх нөхцөл бололцоог хангахтай холбоотой харилцаанд
талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.
2 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай саналаа нөгөө
талдаа тэмцээн эхлэхээс 10 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Гэрээ
цуцалсны улмаас учирсан хохирлыг буруутай тал 100% барагдуулна.

ХОЁР. Гэрээний хугацаа

- 1 Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс буюу 2016 оны 06-р
сарын 20-ны өдрөөс 2016 оны 07-р сарын 28-ныг хүртэлх хугацаанд гэрээ
хүчин төгөлдөр үйлчилнэ.

ГУРАВ. Захиалагчийн эрх, үүрэг

- 1 Захиалагч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
 - 1.1. Захиалагч нь Нийслэлийн Засаг даргын дэргэдэх оюутны шигшээ багийн
жүдо бөхийн баг тамирчдын бэлтгэл сургуулилт хийхэд шаардагдах хөрөнгө
мөнгийг гаргах,
 - 1.2. Захиалагч нь гүйцэтгэгчээс гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах
эрхтэй;
 - 1.3. Бэлтгэл, сургуулилтын чанар, гүйцэтгэл, санхүүжилтийн зарцуулалтанд
хяналт тавьж, үр дүнг тооцох.

ДӨРӨВ. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 1 Гүйцэтгэгч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

1. Гүйцэтгэгч нь захиалагчаас гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй;
2. Гүйцэтгэгч нь гэрээний хугацаан бэлтгэл сургуулилтыг олон улсын стандартын дагуу хийлгэх,

ТАВ. Төлбөр тооцоо

- 1 Гэрээгээр гүйцэтгэх ажлын хөлс нийт 5.000.000 төгрөг байна.
- 2 Гэрээний төлбөрийг гүйцэтгэгчийн Хаан банкны 5031288961 тоот дансанд шилжүүлэнэ.

ЗУРГАА. Бусад зүйл

- 1 Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах (техник, санхүү, бизнесийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн болон аман хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 2 Гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа нь талууд хууль буюу гэрээнд заасны дагуу аливаа хариуцлага хүлээх, гомдлын шаардлага гаргах хугацаанд нөлөөлөхгүй.
- 3 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талынхаа албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчлэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.
- 4 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 5 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болох ба талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.
- 6 Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэх ба тус бүр адил эрх зүйн хүчин чадалтай байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч тал:

Нийслэлийн биеийн тамир,
спортын газар, Оюутны шигшээ
багийн ахлах дасгалжуулагч
Ө.Рагчаадорж
Утас: 99190389

Гүйцэтгэгч тал:

“Монголын жudo бөхийн холбоо” ТББ
Хуулийн зөвлөх Д.Дашбямба

Утас: 99840308

